



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2019.05.23 № 17

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр хилийн чанадад байгаа монгол иргэдэд чиглэсэн цогц бодлогыг боловсруулах, Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаажуулах, монгол хэл, соёл, урлаг, зан заншлыг тээгч улс орнуудын соёлын солилцоо, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий "Дэлхийн Монголчууд" хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан билээ.

Дээрх хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд нийт 88 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85 ажлыг бүрэн хэрэгжсэн тухай холбогдох тайланд дурдсан байна.

Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, гадаадад амьдарч буй монголчуудын тоо, мэдээлэл, статистикийг боловсронгуй болгох, тэднийг эх орондоо эргэн ирж ажил хөдөлмөр эрхлэхийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтарсан байдлаар дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх, Монгол Улсыг гадаадад сурталчлах, иргэдийн эв нэгдлийг бэхжүүлэх зорилготой олон талт үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлж хамtran ажиллах, гадаад улсад ажиллаж байгаа монголчуудад төрөөс үзүүлдэг нийгмийн халамж үйлчилгээ, даатгалд хамруулах болон бусад хуулиар тогтоосон эрхийг нь эдлүүлэх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөвчлөх гэх зэрэг асуудлууд шийдлээ хүлээсээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Танд "Дэлхийн Монголчууд" хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид хүрэхээр тооцож байгаа үр дүн болон төлөвлөсөн ажлын талаараа асуулга тавьж байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Н.УЧРАЛ



0000000080